



# ЦАГААН САР БА ЭДИЙН ЗАСАГ



Улаанбаатар хот 2020 он

Улс, үндэстэн бүр шинэ жилийн баярыг өөр өөрийн ёс заншлаар, өөр, өөр хугацаанд тэмдэглэн бүгд л хуучин бүхнийг үдэж, шинэ жилээ баяр хөөртэй угтдаг. Шинэ жилийн баярыг хэзээ анх тэмдэглэх болсныг яг тогтоосон түүхийн эх сурвалж байхгүй ч дэлхий даяар их л эртнээс тэмдэглэжээ.

Монголчууд бид хуанлийн аргын болон билгийн тооллоор шинэ жилийн баярыг жилдээ хоёр удаа тэмдэглэдэг улс, үндэстний нэг юм.

Билгийн тооллын жилийн эхэн буюу хаврын тэргүүн сарыг угтан тэмдэглэдэг шинэ жилийн баяр бол “Цагаан сар” юм. Энэ баяр нь өвлийг өнтэй давж, хавартай хавтай сайхан золгож, нэг нас нэмсний баяр билээ. Аав, ээж, ихэс дээдэс, бие биесээ хүндэтгэх, ураг садны хэлхээ холбоо батжих, овог удам судраа мэдэх, залуу үеэ энэрэн сургаалаа хайрлах олон ёс заншлыг хадгалсан Монголчуудын уламжлалт баяр юм. Бид энэ баяраар ард түмний эв нэгдэл, үндэсний өв уламжлал, соёл, зан заншлаараа бахархдаг.

Монголчуудын уламжлалт баяр “Цагаан сар”-ыг тэмдэглэх нь ард иргэдийн амьдрал, улс орны эдийн засагт хэрхэн нөлөөлж байгааг харуулах энэ судалгааг бидний хэсэг судлаачид 2016 оноос хойш Та бүхэнд тогтмол танилцуулж байна.


Энэ судалгааны дүгнэлт, санал зөвлөмж нь зөвхөн судлаачийн үзэл бодлыг илэрхийлэхийг анхаарна уу.

Н.Өлзийханд

## 1. ЦАГААН САР БА ЭДИЙН ЗАСАГ

Цагаан сарын баяр улсын эдийн засагт хэрхэн нөлөө үзүүлж байгааг харахын тулд Монголбанкнаас гүйлгээнд гаргасан бэлэн мөнгөний үзүүлэлт, Хүнсний бараа, ундаа, усны хэрэглээний үнийн индексийг түлхүүр үзүүлэлт болгон сонгон авлаа.

Зураг 1. Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө, сар бүрийн эцэст, тэрбум төгрөг




Эх сурвалж: Монголбанк, Монголбанкны статистикийн сарын бюллетень

Тухайн жилийн билгийн тооллын шинийн нэгний өдөр аргын тооллын хэдэн сарын хэдэнд тохиохоос хамааран эдийн засагт үзүүлж буй нөлөөлөл нь 1, 2 дугаар сарын аль алинд гардаг. Учир нь бусад баяраас Цагаан сарын баярын ялгарах онцлог нь нэлээдгүй бэлтгэл ажил шаарддаг юм. Жишээ нь: 2017 оны шинийн нэгэн 2 дугаар сарын 27-ны өдөр байсан учраас баярыг угтсан үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний ихэнх зардал 2 дугаар сард гарсан байх

магадлалтай бол 2018 онд 2 дугаар сарын 16-нд байсан учир баярын бэлтгэл ажил 1 дүгээр сараас 2 сарыг дамнасан байх магадлалтай. Харин 2019 оны шинийн нэгэн 2 дугаар сарын 5-нд тохиож байсан учир баярын бүх бэлтгэл ажил 1 дүгээр сард хийгдсэн байх магадлалтай.

Цагаан сарын баяраар ахмад настнаа хүндэтгэн золгохдоо гар хоосон золгодоггүй уламжлалын дагуу хадаг, торго зэрэг бэлэг, сэлт барьж золгодог байсан. Энэ уламжлалт бэлэг нь орчин үед “шинэ” мөнгөн дэвсгэрт болон солигдсон. Үүнтэй холбоотой цагаан сарын баярын өмнө шинэ мөнгөн дэвсгэртийн эрэлт ихсэх болсон. Нөгөө талдаа Монголбанкнаас гүйлгээнд гаргасан бэлэн мөнгөний хэмжээ (Зураг 1) 2017 оны 2 дугаар сард болон 2019 оны 1 дүгээр сард хамгийн өндөр байгаа нь цагаан сарын баяртай давхцаж байгаа юм. Үүнээс харахад Монголбанкнаас цагаан сарын баярын өмнө бусад саруудтай харьцуулахад илүү их бэлэн мөнгийг гүйлгээнд гаргадаг байна.

Зураг 2. Арилжааны банкнуудын олгосон цалин, тэтгэврийн зээл, сараар, тэрбум төгрөг



Эх сурвалж: Монголбанк, Монголбанкны статистикийн сарын бюллетень

Арилжааны банкуудын олгосон цалин, тэтгэврийн зээлийн сүүлийн 3 жилийн мэдээллээс харахад 2017 оны 2 дугаар сард 508.0 тэрбум төгрөгийн зээл олгосон нь тухайн оны дундаж зээл олголтоос 40 хувиар илүү байжээ.


Харин 2018, 2019 онуудын 2 дугаар саруудад олгосон зээлийн хэмжээ харгалзах жилүүдийн дундажаас доогуур байгаа төдийгүй 2017 онтой харьцуулахад 2018 оны 2 дугаар сард 335.3 тэрбум төгрөг болж 34.0 хувиар, 2019 оны оны 2 дугаар сард 97.7 тэрбум төгрөг болж 80.8 хувиар буурсан байна.

Эндээс дүгнэхэд ахмад настан болоод айл өрхүүд 2017 онтой харьцуулахад сүүлийн 2 жилд цагаан сарын баяр тэмдэглэхээр цалин, тэтгэврийн зээл авах нь эрс багасаж байгааг харж болохоор байна.

Хэрэглээний үнийн индекс нь инфляцын түвшинг тодорхойлох, төрөөс санхүү, мөнгө зээлийн бодлогыг хэрэгжүүлэх, хүн амын цалин, тэтгэвэр, тэтгэмж бусад орлогын хэмжээг индексжүүлэх тооцооны гол үзүүлэлт болдог.

Бидний тэмдэглэж заншсан уламжлалт баяр инфляцын түвшинд хэрхэн нөлөөлж байгааг тооцоолохын тулд хэрэглээний үнийн индексийн сар бүрийн өөрчлөлтийг сонгон авсан юм. Тэр дундаа цагаан сарын баярын салшгүй хэсэг бол идээ, шүүс, зоог байдаг учир хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнийн өөрчлөлтийг нарийвчлан Зураг 3-т харуулсан болно.

Зураг 3. Хүнсний бараа, ундаа, усны хэрэглээний үнийн индекс, сар бүрийн өөрчлөлт



Эх сурвалж: YCX, Хэрэглээний үнийн мэдээ

Зураг 3-аас харахад цагаан сарын баярын бэлтгэл ажил ид өрнөж буй үед хүнсний бараа, ундаа, усны хэрэглээний үнийн өсөлт хамгийн өндөр буюу 2.7-3.4 хувьтай байна.

Хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнийн өсөлтийн 30 орчим хувийг махны үнийн өсөлт эзэлдэг. Үүнээс үзэхэд цагаан сарын баярын үеэр иргэдийн хүнсний бүтээгдэхүүний эрэлт нэмэгддэг учраас зах зээлийн хуулиараа үнийн өсөлт бий болж улмаар инфляцын түвшин нэмэгдэхэд хүргэдэг байна.

## 2. ЦАГААН САР БА ҮЙЛДВЭРЛЭЛ

Монгол улсын хөнгөн үйлдвэрийн салбар сүүлийн жилүүдэд нэлээд хөгжиж байгаа бөгөөд үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний нэр төрлийн тоо нэмэгдсээр байгаа билээ.

Цагаан сарын баяр нь дотоодын үйлдвэрлэгчдийн, тэр дундаа жижиг, дунд бизнес эрхлэгчдийн хувьд гол борлуулалтын үе гэж хэлж болно. Цагаан сарын баярын тавгийн идээ (хэвийн боов, ааруул, чихэр), баярын гоёлын хувцас (дээл), гарын бэлгийн (оймс) үйлдвэрлэл яг энэ үед хамгийн өндөр байдаг.

Хүснэгт 1. Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл

Бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2017 он			2018 он			2019 он		
		1 сар	2 сар	3 сар	1 сар	2 сар	3 сар	1 сар	2 сар	3 сар
Гурил	мян.тн	21.2	21.3	14.4	22.5	12.6	27.3	24.7	10.6	14.7
Хэвийн боов	тн	150.0	249.1	2.8	229.5	169.5	18.0	354.8	125.3	8.9
Ааруул	тн	12.9	46.9	7.0	21.8	24.1	5.9	40.7	16.3	6.4
Чихэр	тн	3.2	19.4	1.3	12.7	12.7	1.4	23.5	3.1	2.0
Архи	сая.л	2.2	2.1	1.8	2.5	3.4	1.8	2.7	1.9	2.1
Оймс	мян.хос	119.4	354.4	59.5	252.7	181.6	198.6	471.8	419.7	344.3
Монгол дээл, тэрлэг	ш	384	729	111	772	2740	205	16828	1605	182


Эх сурвалж: YCX, Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл, борлуулалтын сарын мэдээ

Дээрх хүснэгтээс харахад цагаан сарын баярыг угтан (1 болон 2 дугаар саруудад) 2017 онд 399.1 тонн хэвийн боов, 59.8 тонн ааруул, 22.6 тонн чихэр, 4.3 сая литр архи, 473.8 мянган хос оймс, 1113 дээл үйлдвэрлэж байсан бол 2019 онд хэвийн боов 480.1 тонн болж 20.3 хувиар, чихэр 26.6 тонн болж 17.8 хувиар, архи 4.6 сая литр болж 5.3 хувиар, оймс 891.5 мянган хос болж 88.2 хувиар, дээл 18 433 ширхэг болж 16.5 дахин нэмэгджээ.

Харин ааруулын үйлдвэрлэл 2019 онд 57.0 тонн болсон нь 2017 оноос 4.6 хувь буурсан байна. Жил бүрийн цагаан сарын дараа буюу 3 дугаар сард дээрх бүтээгдэхүүний үйлдвэрлэл эргэж буурч байгааг харж болохоор байна. (1212.mn)

Эндээс монгол дээл, тэрлэгийн үйлдвэрлэл нэлээдгүй анхаарал татаж байгаа ба дээлийн үйлдвэрлэлийг сүүлийн гурван жилийн сар бүрээр задлан харвал “Цагаан сарын баяр” болон “Үндэсний их баяр наадам”-ын үеэр буюу жил бүрийн нэг, хоёр, зургаа, долоо дугаар саруудад үйлдвэрлэл эрчимждэг нь харагдаж байна. (Зураг 4)

Зураг 4. Монгол дээлийн үйлдвэрлэл, сараар, ширхэг



Эх сурвалж: Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл, борлуулалтын сарын мэдээ

### 3. ЦАГААН САРЫН ИДЭЭ, ГАРЫН БЭЛЭГ

Цагаан сар тэмдэглэж буй айл бүр хүрэлцэн ирсэн ах дүү, төрөл садан, зочид, гийчдээ хүндэтгэн идээ ундаа бэлтгэж, ирсэн хүн бүрийн гарыг цайлгаж, өргөн дэлгэр тэмдэглэдэг сайхан уламжлалтай билээ.

Цагаан сарын баярт зориулж бор болон цагаан гэсэн хоёр төрлийн идээ бэлтгэдэг бөгөөд бор идээнд бүхэл мах, бууз, банш, шимийн архи зэрэг ордог бол цагаан идээнд бүх төрлийн цагаан идээ, ул боов, боорцог, айраг зэрэг ордог байна.

Бид энэ судалгаанд Үндэсний Статистикийн хорооны хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрөл, зах зээлийн дундаж үнийн сар бүрийн мэдээллийг ашиглан Цагаан сарын баярын идээ болон гарын бэлгийн нийт үнийг тооцоолон доорх зураг, хүснэгтүүдэд харууллаа.

Нэг өрхийн бор идээний хэрэглээ 2020 онд дунджаар 499.8 мянган төгрөг болж байгаа бөгөөд үүний 56.0% - ийг хонины ууцны зардал эзлэхээр байна.

Зураг 5. Өрхийн бор идээний дундаж хэрэглээ, бүтээгдэхүүний төрлөөр, зах зээлийн дундаж үнэ<sup>1</sup>, төгрөг



<sup>1</sup> ҮСХ, Хэрэглээний үнийн мэдээ

<sup>2</sup> 2020 оны 1 дүгээр сарын 9-ний байдлаар, чанах үнэ орсон

<sup>3</sup> Дундаж орцын хэмжээнээс хамааруулж тооцоолсон

Нэг өрхийн цагаан идээний хэрэглээ 2020 онд дунджаар 299.2 мянган төгрөг байх төлөвтэй байна. (Хүснэгт 2)

Хүснэгт 2. Нэг өрхийн цагаан идээний дундаж хэрэглээ, бүтээгдэхүүний төрлөөр, тоо хэмжээ, зах зээлийн дундаж үнэ

№	Бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ <sup>1</sup>	Нэгжийн зах зээлийн дундаж үнэ <sup>2</sup> , төгрөг	Нийт үнэ, төгрөг
1	Хэвийн боов	ш	21	2 600	54 600
2	Ааруул	кг	2	14 664	29 327
3	Ёотон	хайрцаг	1	2 085	2 085
4	Цагаан будаа	кг	2	3 530	7 060
5	Элсэн чихэр	кг	1	2 726	2 726
6	Үзэм	кг	0.5	8 647	4 324
7	Сүү	л	5	2 661	13 307
8	Төмс	кг	8	950	7 603
9	Лууван	кг	2	1 426	2 852
10	Хиам	кг	5	8 268	41 339
11	Өргөст хэмх	шил	3	5 655	16 965
12	Майонез	л	2	4 898	9 795
13	Ундаа	ш	10	2 325	23 254
14	Чихэр	кг	5	7 867	39 335
15	Алим	кг	3	4 191	12 574
16	Мандарин	кг	3	5 343	16 029
17	Гадил	кг	3	5 355	16 064

Эх сурвалж:<sup>1</sup> Судлаачийн таамаглал

<sup>2</sup> ҮСХ, Хэрэглээний үнийн мэдээ

Гарын бэлэг дотроо олон янз бөгөөд урьд цагт хамгийн хүндтэй хүндээ ар сайтай торго дурдан, алт, мөнгөн эдлэл, сор сайтай ангийн үс, судар ном сэлтийг есөн цагааны бэлгийн хамт барьдаг байжээ. Хэдийгээр цаг ирэх тусам бэлэг барих ёсон өөрчлөгдөж байгаа ч эртнээс нааш

уламжилж ирсэн хадаг, торго, аяга, цай нь нэн хүндэтгэлтэй бэлэг хэвээр байсаар байна. (Хүснэгт 3)

Хүснэгт 3. Гарын бэлэг, бүтээгдэхүүний төрлөөр, зах зээлийн дундаж үнэ\*

№	Бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	Нэгжийн зах зээлийн дундаж үнэ, төгрөг
1	Торго	м	8 000
2	Гүрж ногоон цай	ш	1 525
3	Тамхи, дотоодын	хайрцаг	2 007
4	Тамхи, импортын	хайрцаг	4 187
5	Цамц, импортын	ш	27 000
6	Оймс	ш	2 243
7	Хүүхдийн трико	ш	5 839
8	Хүүхдийн оймс	ш	1 720
9	Гар нүүрийн алчуур	ш	5 775
10	Хөлөгт тоглоом	ш	12 394
11	Барби хүүхэлдэй	ш	11 572
12	Эмэгтэй хүний нүүрний энгэсэг	ш	14 216
13	Биеийн шингэн тос	ш	5 982
14	Шоколад	ш	2 351
15	Сникерс	ш	1 181
16	Шоколадны крем	ш	3 127

\* - Үндэсний Статистикийн хорооноос тооцож нийтэд мэдээлдэг, хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индексийн тооцоонд ашигладаг, хэрэглээний сагснаас гарын бэлэгт бэлэглэж болохуйц бүтээгдэхүүнийг нэр төрлөөр зах зээлийн дундаж үнийг харуулав.

Тооцооллоор 2020 оны цагаан сарын баярт зориулж нэг өрхөөс идээний зардалд дунджаар 799.0 мянган төгрөгийн зардал гарах бол үүнээс 499.8 мянган төгрөг буюу 62.6 хувь нь бор идээний, 299.2 мянган төгрөг буюу 37.4 хувь нь цагаан идээний зардалд зориулагдахаар байна.

Харин гарын бэлэгт нэг хүнд дунджаар 8.0-27.0 мянган төгрөгийн үнэ бүхий зүйл бэлэглэнэ гэж үзвэл, нэг хүнд өгөх бэлгийн зардлыг тооцож, нэг өрх дунджаар 60 зочин хүлээн авна гэж үзээд нэг өрх бэлэгт нийтдээ 1050.0 мянган төгрөг зарцуулахаар байна.

Сүүлийн жилүүдэд монголчууд үндэсний хувцас дээлээрээ гоёх хандлага нэмэгдсэнээр цагаан сарын үеэр дээлийн үйлдвэрлэл, борлуулалт эрс нэмэгдэх болсон. 2020 оны 1-р сарын байдлаар Нарантуул зах дээр борлуулагдаж байгаа эрэгтэй, эмэгтэй хүний дээлийн үнэ 120.0-250.0 мянган төгрөг байгаа бол хос дээлийн үнэ 250.0-450.0 мянган төгрөгийн үнэтэй байна. Харин хүүхдийн дээл 75.0-100.0 мянган төгрөгийн хооронд хэлбэлзэж байна. Монгол Улсын нэг өрх дунджаар 3.7 гишүүнтэй байдаг ба нэг өрхийн баярын гоёлдоо зарцуулах зардлыг ам бүлийн тоотой уялдуулан тооцвол нэг өрх дунджаар 377.5 мянган төгрөг зарцуулахаар байна.


Дээрх гурван төрлийн зардлын нийлбэрээр буюу идээ, гарын бэлэг, баярын гоёлын нийлбэр дүнгээр нэг өрх 2020 оны цагаан сарын баярт дунджаар 2.2 сая төгрөгийн зардал гаргахаар байна.

#### 4. ӨРХИЙН ЗАРЛАГА

Үндэсний статистикийн хорооны “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа (ӨНЭЗС)” – гаар цагаан сарын баярын үед өрхийн сарын дундаж зарлагад дараах өөрчлөлтүүд гарч байна. Үүнд:

- ❖ Нэг өрхөөс цагаан сарын баяр тэмдэглэхэд гардаг дундаж зардал 2018 онд 814.2 мянган төгрөг болсон нь өмнөх оноос 71.7 мянга буюу 9.7 хувиар нэмэгдсэн байна (Зураг 6).
- ❖ 2018 онд инфляцын түвшин 8.1 хувь байсан ба өрхийн зардлаас үнийн нөлөөллийг арилган тооцвол өрхийн бодит зардал 2017 оноос 1.4 хувиар нэмэгдсэн байна.

Зураг 6. Нэг өрхөөс цагаан сар тэмдэглэхэд гардаг дундаж зардал, мян.төг



Эх сурвалж: ҮСХ, Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа


Нэг өрхөөс цагаан сарын баяр тэмдэглэхэд гардаг дундаж зардлыг өрхийн тэргүүний насны бүлгээр авч үзвэл:

- 30 хүртэлх насны өрхийн тэргүүнтэй өрхийн зардал 494.6 мянган төгрөг,
- 30-39 насны өрхийн тэргүүнтэй өрхийн зардал 644.9 мянган төгрөг,
- 40-49 насны өрхийн тэргүүнтэй өрхийн зардал 757.2 мянган төгрөг,
- 50-59 насны өрхийн тэргүүнтэй өрхийн зардал 915.5 мянган төгрөг,
- 60-аас дээш насны өрхийн тэргүүнтэй өрхийн зардал 1189.0 мянган төгрөг байна.

2018 онд 30 хүртэлх насны өрхийн тэргүүлэгчтэй өрхийн зардал өмнөх оноос 30.6 мянган төгрөгөөр (6.6%), 30-39 насны өрхийн тэргүүлэгчтэй өрхийн зардал 53.0 мянган төгрөгөөр (9.0%), 40-49 насны өрхийн тэргүүлэгчтэй өрхийн зардал 77.0 мянган төгрөгөөр (11.3%), 50-59 насны өрхийн тэргүүлэгчтэй өрхийн зардал 58.9 мянган төгрөгөөр (6.9%), 60-аас дээш насны өрхийн тэргүүлэгчтэй өрхийн зардал 94.7 мянган төгрөгөөр (8.7%) тус тус өсжээ.

Зураг 7. Нэг өрхийн хүнсний дундаж хэрэглээ, 2018 оны сар бүрээр, мян.төг

Жилийн дундаж зардал-  
293.7 мянган төгрөг




Эх сурвалж: ҮСХ, Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа

Үнийн нөлөөллийг арилган тооцоход 40-49 насны өрхийн тэргүүлэгчтэй өрхийн зардал хамгийн өндөр буюу 3.0 хувиар нэмэгдсэн бол 30 хүртэлх насны өрхийн тэргүүлэгчтэй өрхийн зардал 1.4 хувиар буурсан байна.

Нэг өрхийн хүнсний дундаж хэрэглээг 2018 оны сар бүрээрх мэдээллээс харахад цагаан сар, наадам, шинэ жилийн баяр болдог саруудад хамгийн өндөр хэрэглээтэй байдаг байна. (Зураг7)



Зураг 8. Нэг өрхийн “Цагаан сарын баяр”-ын хүнсний хэрэглээний өсөлт, бусад сарын дундажтай харьцуулснаар, хамгийн өндөр өсөлттэй бүтээгдэхүүний хувьд



Нэг өрхийн зарцуулж буй хүнсний зардал нь 2 дугаар сард бусад саруудаасаа өсдөг хүнсний бүтээгдэхүүнийг харахад айраг, вандуй, майонез, өргөст хэмх, архи, хөлдөөсөн бууз баншний хэрэглээ хамгийн өндөр буюу 2-4.3 дахин нэмэгддэг байна.

Эх сурвалж: ҮСХ, Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа

Монгол Улсын нийт өрхийг өрхийн тэргүүний насны бүлгээр авч үзвэл, 30 хүртэлх насны өрхийн тэргүүнтэй өрх (I) нийт өрхийн 11.0 хувь, 30-39 насны өрхийн тэргүүнтэй өрх (II) нийт өрхийн 26.9 хувь, 40-49 насны өрхийн тэргүүнтэй өрх (III) нийт өрхийн 24.9 хувь, 50-59 насны өрхийн тэргүүнтэй өрх (IV) нийт өрхийн 20.1 хувь, 60-аас дээш насны өрхийн тэргүүнтэй өрх (V) нийт өрхийн 17.1 хувийг эзэлж байна.

Цагаан сарын баярыг:

- Нэгдүгээр өрхүүдийн 25.0 хувь
- Хоёрдугаар өрхүүдийн 45.0 хувь
- Гуравдугаар өрхүүдийн 65.0 хувь
- Дөрөвдүгээр өрхүүдийн 85.0 хувь
- Тавдугаар өрхүүдийн 95.0 хувь

нь тэмдэглэдэг гэж таамаглавал нийт өрхийн 64.0 хувь нь 2020 онд цагаан сарын баярыг тэмдэглэн өнгөрүүлэх төлөвтэй байна.

## ДҮГНЭЛТ

ҮСХ-ны “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа”-ны мэдээллээс харахад нэг өрхийн хүнсний дундаж зардал цагаан сар, наадам, шинэ жилийн баяр болдог саруудад хамгийн өндөр байгаа нь харагдаж байна.

Бидний таамагласнаар 2020 онд Монгол Улсын нийт өрхийн 64.0 хувь нь Цагаан сарын баярыг тэмдэглэн өнгөрүүлж, нэг өрх дунджаар 2.2 сая төгрөгийг идээ цагаа, гарын бэлэг, баярын гоёлд зарцуулна гэвэл, улсын хэмжээнд Цагаан сарын баярт ойролцоогоор 1.2 их наяд төгрөгийн зардал гарахаар байна. Тус зардлыг бүтцээр нь задалбал идээ, цагаа, бусад хүнсний зардалд нийт зардлын 36.0 хувь, гарын бэлэгт нийт зардлын 47.0 хувь, баярын гоёлд нийт зардлын 17.0 хувийг зарцуулахаар байна. Өөрөөр хэлбэл, тухайн хэмжээний мөнгө зах зээлийн эргэлтэд орно гэсэн үг юм.

Жилийн энэ үед Монголбанкнаас гүйлгээнд гаргасан мөнгөний хэмжээ нэмэгддэг нь ч Цагаан сарын баяртай холбоотой. Нэг талаасаа зах зээлд гүйлгээнд оролцож буй бэлэн мөнгөний хэмжээ ихсэх нь инфляц нэмэгдэхэд шууд нөлөөлдөг хэдий ч нөгөө талдаа иргэдийн худалдан авах эрэлт нэмэгдэх нь хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнийг өсгөж байдаг. Иймээс энэ жилийн Цагаан сарын баярын үеэр мөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ, тэр дундаа хүнсний бараа ундаа усны бүлгийн үнэ өмнөх сараасаа 3.0-3.2 хувиар өсөх хандлагатай байна.

Сүүлийн 2 жилд 2017 онтой харьцуулахад Цагаан сарын баяр тэмдэглэхэд гаргадаг өрхийн бодит зардал өсөхийн зэрэгцээ иргэдийн цалин, тэтгэврийн зээлийн хэмжээ буурчээ. Цагаан сарын баярын үед өрхийн гаргадаг зардлаас үнийн нөлөөллийг арилган тооцоход нэг өрхийн бодит зардал 2018 онд өмнөх оноос 1.4 хувиар нэмэгдэж, тэр дундаа 40-49 насны өрхийн тэргүүлэгчтэй өрхийн зардал хамгийн өндөр буюу 3.0 хувиар нэмэгдсэн байна.

Үйлдвэрлэлийн өсөлтөөс харахад цагаан сарын баяраар дотоодын үйлдвэрлэгч аж ахуйн нэгж, байгууллага, үйлдвэрийн газар, хувиараа хөдөлмөр эрхлэгчид хамгийн их ачаалалтай ажилладаг бөгөөд хамгийн их борлуулалт хийдэг нь харагдаж байна. Жишээ нь, зөвхөн дээл үйлдвэрлэлийн салбарын хувьд 2020 оны Цагаан сарын баяр 212.2 тэрбум төгрөгийн эрэлт бий болгох таамаг байна.

Монголчууд дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг “Цагаан сар”-ын баяраар өргөн хэрэглэвэл баярын үеэр гадагш урсах валютын урсгалыг сааруулахад эергээр нөлөөлөөд зогсохгүй ажилгүйдэл буурах, төгрөгийн худалдан авах чадвар сайжрах зэргээр манай улсын эдийн засагт олон эерэг үр дүн гарна.

-----oOo-----